



**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2019 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/22

Улаанбаатар хот

Ээлжит бус хуралдаан
хуралдуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 23 дугаар зүйлийн 23.3, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Сонгинохайрхан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сонгинохайрхан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус хуралдааныг 2019 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 11 цагт хуралдуулж, дараах асуудлуудыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:

1.1 Дүүргийн 2018 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай

1.2 Дүүргийн 2019 оны батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

1.3 Дүүргийн зарим хороодыг өөрчлөн зохион байгуулж, хороо байгуулах асуудлыг дэмжиж уламжлах тухай

2. Хуралдааныг зохион байгуулахад шаардагдах зардлыг тооцож, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны төсвийн бараа үйлчилгээний бусад зардлаас гаргахыг Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Н.Мөнхбаатар/-д зөвшөөрсүгэй.

3. Хуралдааны бэлтгэлийг зохион байгуулалтын өндөр түвшинд хангаж ажиллахыг Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Н.Мөнхбаатар/, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Төмөрбаатар/ нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Б.МӨНХЦЭЦЭГ